



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дарьганга сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

СБА-2022/39/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Баруун-Урт сум

2022 он

Тэргүүлэх аудитор: М.Нарантуяа

Утас: 70518369

Цахим хаяг: [narantuyam@audit.gov.mn](mailto:narantuyam@audit.gov.mn)

Аудитын менежер: Г.Даваа

Утас: 70512123

Цахим хаяг: [davaag@audit.gov.mn](mailto:davaag@audit.gov.mn)

Аудитор:

Б.Ариунзул

Утас: 70512127

Цахим хаяг: [Ariunzulb@audit.gov.mn](mailto:Ariunzulb@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
3. Аудитын тайлан .....	13
3.1 Ерөнхий зүйл .....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Материаллаг байдал .....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал .....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	15
4. Аудитын илрүүлэлт .....	16
4.1 Зөвлөмж.....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	17

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг  
Утас: 70518396, Факс: 70518396  
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

᠑᠐᠘᠘.᠐᠘.᠒᠖ № 38  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

СҮХБААТАР АЙМГИЙН ДАРЬГАНГА  
СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ Ю.СОЁЛМАА ТАНАА

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дарьганга сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дарьганга сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *М.Нарантуяа* М.НАРАНТУЯА



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>24,448,658.07</u></b>	<b><u>24,498,749.47</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	174,080.00	72,500.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	174,080.00	72,500.00
3351	Байгууллагаас авах авлага	174,080.00	72,500.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	24,274,578.07	24,426,249.47
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	1,735,110.00	756,160.00
35130	Эм боох материал	1,735,110.00	756,160.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	22,539,468.07	23,670,089.47
35410	Бичиг хэргийн материал	1,852,400.00	1,631,400.00
35420	Аж ахуйн материал	17,184,568.07	16,552,104.47
35440	Түлц, шатах тослох материал	388,000.00	825,000.00
35450	Барилгын засварын материал	2,818,500.00	2,172,500.00
35460	Хүнсний материал	00.00	2,193,085.00
35470	Бусад хангамжийн материал	296,000.00	296,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>78,517,339.17</u></b>	<b><u>81,615,956.81</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	78,517,339.17	81,615,956.81
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	71,969,339.17	75,067,956.81
39201	Барилга, байгууламж, орон сууц	66,833,340.00	66,833,340.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-16,113,669.84	-20,357,704.48
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	25,473,400.00	27,134,600.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-13,996,280.17	-11,151,440.21
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	23,675,359.32	27,522,185.24
39208	Хуримтлагдсан элэгдэл	-15,295,410.14	-17,820,528.74
39214	Бусад үндсэн хөрөнгө	7,997,285.00	3,538,035.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-7,997,285.00	-3,538,035.00
39217	Ном	1,392,600.00	2,907,505.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	6,548,000.00	6,548,000.00
39301	Програм хангамж	100,000.00	100,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-100,000.00	-100,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	6,548,000.00	6,548,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН Ш=I+II</b>	<b><u>102,965,997.24</u></b>	<b><u>106,114,706.28</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>4,898.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	00.00	4,898.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	00.00	4,898.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	00.00	4,898.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	4,898.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>102,965,997.24</u></b>	<b><u>106,109,808.28</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	102,965,997.24	106,109,808.28
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	210,172,151.87	210,172,151.87
51101	Өмч: - төрийн	210,172,151.87	210,172,151.87
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-168,908,584.33	-165,764,773.29
51210	Өмнөх үеийн үр дүн	-168,908,584.33	-168,908,584.33
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	3,143,811.04

Дарьганга сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	61,702,429.70	61,702,429.70
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>102,965,997.24</b>	<b>106,114,706.28</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>379,490,900.00</b>	<b>381,165,577.92</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,499,000.00</b>	<b>15,512,077.92</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	3,499,000.00	15,512,077.92
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,499,000.00	15,512,077.92
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	251.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,499,000.00	15,511,826.92
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>23,800,700.00</b>	<b>23,720,600.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	352,191,200.00	341,932,900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	00.00	140,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	140,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	23,800,700.00	23,580,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	23,800,700.00	23,580,600.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>384,264,879.67</b>	<b>378,021,766.88</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>384,264,879.67</b>	<b>378,021,766.88</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	360,254,450.71	371,464,270.13
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	263,271,106.00	273,126,748.41
210101	Үндсэн цалин	162,962,686.97	182,782,260.86
210102	Нэмэгдэл	73,765,269.38	68,747,544.30
210104	Урамшуулал	26,543,149.65	21,596,943.25
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	32,809,712.72	35,396,599.97
210201	Тэтгэврийн даатгал	22,503,722.21	24,733,208.66
210202	Тэтгэмжийн даатгал	2,657,911.25	2,752,191.70
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,122,969.57	2,201,753.33
210204	Ажилгүйдлийн даатгал	502,282.73	519,040.61
210205	Эрүүл мэндийн даатгал	5,022,826.96	5,190,405.67
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	20,533,210.32	20,078,749.87
210301	Гэрэл, цахилгаан	1,097,090.32	1,450,689.87
210302	Түлш, халаалт	19,018,860.00	18,579,360.00
210303	Цэвэр, бохир ус	417,260.00	48,700.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2,381,662.00	3,569,163.60
210401	Бичиг хэрэг	219,600.00	363,600.00
210402	Тээвэр, шатахуун	1,550,762.00	340,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	100,000.00	175,000.00
210404	Ном, хэвлэл	12,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	499,300.00	649,900.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	2,040,463.60
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	24,935,690.00	20,618,947.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,286,040.00	837,642.00
210502	Хоол, хүнс	22,994,650.00	19,081,305.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	655,000.00	700,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,522,000.00	3,910,000.00
210604	Урсгал засвар	1,522,000.00	3,910,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	710,000.00	219,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	170,000.00	219,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	00.00

**Дарьганга сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	14,091,069.67	14,545,061.28
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	1,579,398.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,290,000.00	1,949,454.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	12,801,069.67	11,016,209.28
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	24,010,428.96	6,557,496.75
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	24,010,428.96	6,557,496.75
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	24,010,428.96	6,557,496.75
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-4,773,979.67</b>	<b>3,143,811.04</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-4,773,979.67</b>	<b>3,143,811.04</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	210,172,151.87	61,702,429.70	-164,134,604.66	00.00	107,739,976.91
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>210,172,151.87</b>	<b>61,702,429.70</b>	<b>-164,134,604.66</b>	<b>00.00</b>	107,739,976.91
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-4,773,979.67	00.00	-4,773,979.67
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	210,172,151.87	61,702,429.70	-168,908,584.33	00.00	102,965,997.24
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	210,172,151.87	61,702,429.70	-168,908,584.33	00.00	102,965,997.24
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>210,172,151.87</b>	<b>61,702,429.70</b>	<b>-168,908,584.33</b>	<b>00.00</b>	102,965,997.24
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	3,143,811.04	00.00	3,143,811.04
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	210,172,151.87	61,702,429.70	-165,764,773.29	00.00	106,109,808.28

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>375,991,900.00</b>	<b>366,992,451.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>1,338,951.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	00.00	1,338,951.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	00.00	251.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	251.00
120009	Бусад орлого	00.00	1,338,700.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>375,991,900.00</b>	<b>365,653,500.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	352,191,200.00	341,932,900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>00.00</b>	<b>140,000.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	140,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>23,800,700.00</b>	<b>23,580,600.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	23,800,700.00	23,580,600.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>375,884,900.00</b>	<b>366,968,451.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>375,884,900.00</b>	<b>366,968,451.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>351,874,471.04</b>	<b>360,410,954.25</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>263,271,106.00</b>	<b>272,836,748.41</b>
210101	Үндсэн цалин	162,962,686.97	182,782,260.86
210102	Нэмэгдэл	73,765,269.38	68,457,544.30
210104	Урамшуулал	26,543,149.65	21,596,943.25
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>32,809,712.72</b>	<b>35,686,599.97</b>
210201	Тэтгэврийн даатгал	22,503,720.71	25,023,208.66
210202	Тэтгэмжийн даатгал	2,657,911.25	2,752,191.70
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,122,969.57	2,201,753.33
210204	Ажилгүйдлийн даатгал	502,282.73	519,040.61
210205	Эрүүл мэндийн даатгал	5,022,828.46	5,190,405.67
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>20,422,710.32</b>	<b>20,405,749.87</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,097,090.32	1,450,689.87
210302	Түлш, халаалт	19,016,360.00	18,906,360.00
210303	Цэвэр, бохир ус	309,260.00	48,700.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>2,223,762.00</b>	<b>1,183,100.00</b>
210401	Бичиг хэрэг	266,000.00	282,100.00
210402	Тээвэр, шатахуун	1,550,762.00	340,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	89,900.00	175,000.00
210404	Ном, хэвлэл	12,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	305,100.00	385,800.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>26,675,380.00</b>	<b>24,221,802.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,021,150.00	216,942.00
210502	Хоол, хүнс	22,887,330.00	22,686,660.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	766,900.00	1,318,200.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,920,500.00</b>	<b>3,000,000.00</b>
210604	Урсгал засвар	2,920,500.00	3,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>710,000.00</b>	<b>219,000.00</b>

**Дарьганга сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	170,000.00	219,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	00.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,841,300.00</b>	<b>2,857,954.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	868,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,841,300.00	1,989,954.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>24,010,428.96</b>	<b>6,557,496.75</b>
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>24,010,428.96</b>	<b>6,557,496.75</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	24,010,428.96	6,557,496.75
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>107,000.00</u></b>	<b><u>24,000.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b><u>107,000.00</u></b>	<b><u>24,000.00</u></b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b><u>107,000.00</u></b>	<b><u>24,000.00</u></b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>107,000.00</b>	<b>24,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	107,000.00	24,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>-107,000.00</u></b>	<b><u>-24,000.00</u></b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	00.00	00.00	365,519,500.00	358,956,003.25
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	00.00	00.00	365,519,500.00	358,956,003.25
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	00.00	00.00	365,519,500.00	358,956,003.25
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	00.00	00.00	272,846,500.00	272,836,748.41
210101	Үндсэн цалин	00.00	00.00	198,120,900.00	182,782,260.86
210102	Нэмэгдэл	00.00	00.00	50,919,100.00	68,457,544.30
210104	Урамшуулал	00.00	00.00	23,806,500.00	21,596,943.25
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	00.00	00.00	37,810,100.00	35,686,599.97
210201	Тэтгэврийн даатгал	00.00	00.00	27,362,300.00	25,023,208.66
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	00.00	2,611,900.00	2,752,191.70
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	00.00	2,089,600.00	2,201,753.33
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	00.00	522,400.00	519,040.61
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	00.00	5,223,900.00	5,190,405.67
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	00.00	00.00	20,580,600.00	20,405,749.87
210301	Гэрэл, цахилгаан	00.00	00.00	1,813,100.00	1,450,689.87
210302	Түлш, халаалт	00.00	00.00	17,972,600.00	18,906,360.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	00.00	794,900.00	48,700.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	00.00	00.00	1,297,700.00	1,207,100.00
210401	Бичиг хэрэг	00.00	00.00	308,300.00	282,100.00
210402	Тээвэр, шатахуун	00.00	00.00	350,000.00	340,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	00.00	00.00	298,600.00	175,000.00
210404	Ном, хэвлэл	00.00	00.00	71,100.00	24,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	00.00	269,700.00	385,800.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	00.00	00.00	26,414,100.00	22,742,851.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	00.00	226,100.00	216,942.00
210502	Хоол, хүнс	00.00	00.00	24,860,000.00	21,347,709.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	00.00	1,328,000.00	1,178,200.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	00.00	00.00	3,000,000.00	3,000,000.00
210604	Урсгал засвар	00.00	00.00	3,000,000.00	3,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	00.00	00.00	638,000.00	219,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	00.00	638,000.00	219,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	0.00	0.00	2932500.00	2857954.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	00.00	893,000.00	868,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	00.00	2,039,500.00	1,989,954.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	00.00	00.00	365,519,500.00	358,956,003.25
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	00.00	00.00	341,938,900.00	335,550,253.38
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	00.00	00.00	341,938,900.00	335,550,253.38
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	00.00	00.00	23,580,600.00	23,405,749.87
132001	Орон нутгийн төсвөөс	00.00	00.00	23,580,600.00	23,405,749.87
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	00.00	00.00	24.00	24.00
620001	Удирдах ажилтан	00.00	00.00	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	00.00	00.00	07.00	07.00

Дарьганга сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

620003	Үйлчлэх ажилтан	00.00	00.00	16.00	16.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>24.00</b>	<b>24.00</b>
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	00.00	00.00	14.00	14.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	00.00	00.00	10.00	10.00

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дарьганга сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 15-аас 2022 оны 2 дугаар сарын 25-ны хооронд Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Ариунзул гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Дарьганга сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Дарьганга сумын Хүүхдийн цэцэрлэг нь “Багш бүрийн хөгжлийг дэмжиж,эцэг эх асран хамгаалагчийн оролцоо, хамтын ажиллагааг өргөжүүлэн “Эрүүл аюулгүй,эко орчин”-г бүрдүүлэхэд оршино” эрхэм зорилго тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дарьганга сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн нь хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд нийт ажил гүйлгээний ихэнх хувийг зардлын гүйлгээ эзэлдэг бөгөөд төсвийн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байдлыг татвар төлөгч, иргэд илүү анхаардаг учир материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын 366.9 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 5.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 3.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Дарьганга сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая.төг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
<b>Бараа материал</b>	24.2	24.4	0.2
<b>Үндсэн хөрөнгө</b>	78.5	81.6	3.1
<b>Нийт хөрөнгө</b>	<b>102.9</b>	<b>106.1</b>	<b>3.2</b>
<b>Өр төлбөр</b>			
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>102.9</b>	<b>106.1</b>	<b>3.2</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 24.4 сая төгрөг болж 0.2 сая төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 81.6 сая төгрөг болж 3.1 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь хандив тусламжаар тавилга хэрэгсэл, бусад байгууллагаас ном шилжиж ирсэн нь нөлөөлсөн байна.

Дарьганга сумын Хүүхдийн цэцэрлэг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 381.1 сая төгрөг буюу 1 хувиар нэмэгдсэн байна.

Нийт зардал өмнөх оноос 366.9 сая төгрөг буюу 2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь цалин хөлс болон нэмэгдэл, АО-оос НД шимтгэлийн зардал, урсгал зардал, бараа ажил үйлчилгээний бусад зардлууд байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 359.0 сая төгрөгөөр, нийт зарлагыг 359.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийг 359.0 сая төгрөгөөр баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 359.0 сая төгрөгийн төсөв баталснаас ТЗШ-ээс санхүүжих 355.5 сая, орон нутгийн төсвөөс 23.4 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 359.0 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 359.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Дарьганга сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2021 онд гүйцэтгэлийн төлөвлөөгөөр 4 зорилт дэвшүүлэн ажиллаж 80.1 хувьтай хэрэгжсэн байна.

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

Дарьганга сумын Хүүхдийн цэцэрлэг үйл ажиллагаа, тайлант хугацаанд гарсан ажил гүйлгээ, үйл явдал болон засаглах эрх бүхий этгээдүүдийн түвшин дэх харилцаатай холбоотой санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудал байхгүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах асуудал гараагүй.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаcт ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих 140 мэдээллээс хугацаандаа оруулсан 141, хугацаа хоцроож мэдээлсэн 9 мэдээлэл байна.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, үндсэн хөрөнгөтэй холбоотой зөвлөмж өгсөн.

### **4.1 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал**

##### **1.1. Илрүүлэлт:**

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 55 ширхэг 22.6 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т "Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 6.2-т "Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг дараах тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр данснаас хасна", 6.2.1-д "Элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн бөгөөд цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон", "үнэлгээ ба хуваарилалт", "иж бүрэн байх", "үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### **1.2. Өгсөн зөвлөмж:**

Анхны өртгөө хуримтлагдсан элэгдлээрээ бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг холбогдох хууль, эрх зүйн актын хүрээнд санал гаргаж, эрх бүхий байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлэх

#### **2. Шилэн данстай холбоотой асуудал**

##### **2.1 Илрүүлэлт:**

Шилэн дансны [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудаст нийт 140 мэдээллийг ил тод байршуулахаас 9 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.3-т заасан "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" заалт, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам", "иж бүрэн байх", "үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### **2.1 Өгсөн зөвлөмж:**

Шилэн дансны [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй албан тушаалтан мэдээллийг тогтоосон хугацаанд нь тогтмол мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Заглуулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Дарьганга сумын Хүүхдийн цэцэрлэг	2	-	-	-	-	-	-	-	2	-